

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид [Зөвлөхийн үйлчилгээний нэр] үзүүлэхээр санал болгож байна. Бид техникийн болон санхүүгийн саналаа тус тусад нь битүүмжилсэн дугтуйд хийж үүгээр хүргүүлж байна.

Саналын хүчинтэй байх хугацаа санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [30] хоногийн дотор буюу [он, сар, өдөр]-аас өмнө хэлэлцээр хийгдэх бол санал болгож буй ажилтнуудад үндэслэж оролцоно. Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

## 2. САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(СV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_  
Байгууллагын нэр: \_\_\_\_\_  
Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_  
Мэргэжил: \_\_\_\_\_  
Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_  
Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_  
Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_  
Хариуцах ажил: \_\_\_\_\_

### Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

---

### Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

### Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

---

### Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

---

### Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

### 3. АЖЛЫН ХУВААРЬ

#### А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

	<i>[Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт]</i>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Үйл ажиллагаа (ажлууд)												
-----												
-----												
-----												
-----												

#### В. Ажлыг дуусгаж тайлан өгөх

Тайлан	Он, сар, өдөр
1. Эхлэлийн тайлан	
2. Явцын тайлан (а). 1 дэх тайлан (б). 2 дахь тайлан	
3. Тайлангийн төсөл	
4. Эцсийн тайлан	

/хийгдэх ажлын цар хүрээнээс шалтгаалж тайлан хүлээлгэн өгөх хугацаанд өөрчлөлт орж болно/

#### 4. САНХҮҮГИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид [зөвлөхийн үйлчилгээний нэр]-г [санхүүгийн саналын дүнг тоогоор болон үсгээр бичнэ] төгрөгөөр гүйцэтгэхээр санал болгож байна. Энэ үнэд [татварын дүнг тоогоор болон үсгээр] төгрөгийн дотоодын татвар, хураамж орсон болно.

Саналын хүчинтэй байх хугацаа нь санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [30] хоногт буюу [он, сар, өдөр]-аас өмнө хийгдэх гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд бидний санхүүгийн санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:


Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

М. Саандуу (ХХД)  
(Ургууча) Тасвийг нь тодруулж  
[Signature]

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР  
О.ТЭНГИС



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОН ӨРИЙН ЗОХИСТОЙ ТҮВШИНГ ҮНЭЛЖ,  
ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 10 дугаар  
сарын 01-ны өдөр

Дугаар УАС-2020/36А

Улаанбаатар хот

**ЗОРИЛГО:**

Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Монгол улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж төсөвлөгдсөн болон өрийн удирдлага, бодлого зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангасан эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

**1. ҮНДЭСЛЭЛ:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсын 2021 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын төсөвлөлт болон өрийн зохистой түвшинг үнэлж, дүгнэлт өгнө.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно" гэж заасны дагуу уул уурхайн олборлолт, ашиглалтын чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад татан оролцуулах шаардлагатай байна.

**2. ЗОРИЛТ:**

Шинжээч нь Монгол Улсын 2021 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээ болон өрийн түвшин нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан тогтоомжийн бусад актууд, Монгол улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж төсөвлөгдсөн болон өрийн удирдлага, бодлого зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангасан байдалд тулган баталгаажуулалт хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна.

**3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛБАРУУД:**

Шинжээч нь ажлын даалгаварт туссан зорилтын хүрээнд дараах ажилбаруудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээ болон өрийн түвшин нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой

байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудтай нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах;

- Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд туссан хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;
- Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд туссан хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээнд зардал, үр ашгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд туссан Засгийн газрын өрийн хэмжээнд багцын удирдлага, эрсдэлийн удирдлагын шинжилгээг хийж, дүгнэлт гаргах;

#### **4. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ:**

Шинжээч нь Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам болон болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг бүрэн хамруулж дүгнэлт гаргана.

#### **5. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН:**

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гаргаж, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

#### **6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/74 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтарч ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус ажлын хэсгээс үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газартай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

## **7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:**

Шинжээч нь аудитын талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

**Эхлэх хугацаа:** 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр

**Дуусах хугацаа:** 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

## **8. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

Шинжээч нь багаар болон хуулийн этгээдээр оролцож болно. Ажлын даалгаварт заасан зорилго, зорилтын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах чадвартай, эдийн засаг, төрийн санхүү, төсвийн бодлогын чиглэлээр судалгаа шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай байна.

Шинжээч нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай байна. Үүнд:

- Төсөв, санхүү, эдийн засгийн мэргэжлийн чиглэлээр магистр буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 10 буюу түүнээс дээш жил ажилласан, шийдвэр гаргах түвшний хувь хүн болон байгууллагуудад хөгжлийн стратеги, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөөр мэргэжил арга зүйн зөвлөгөө, тайлан дүгнэлт гаргаж, судалгаа, шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Аудитын байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлж, шинжээчээр ажиллаж байсан бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

## **9. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:**

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

**Хянасан:**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  С.ОЮУНГЭРЭЛ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР  Н.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.САРУУЛ

**Боловсруулсан:**  
АХЛАХ АУДИТОР  Б.БАТДЭЛГЭР


*Ахлаагаар:*

*Тавиагаар илгээлтэд шийдсэн Зовлох асуу  
лэр талаар ахлаагаар.*

*- Зовлохгүй гэрээнд нотлох баримтуудыг хэвсэргээр.*







МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ХӨЛСНИЙ ТООЦОО

Аудитын нэр: **Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах**

№	Зардлын зүйл	Ажиллах хүч		Цалингийн зардал		Зардлын нийт дүн
		Хүний тоо	Хоногийн тоо	Нийт ажиллах цаг	1 цагийн хөлс	
1	Хөрөнгө оруулалтын болон өрийн зохистой түвшинг үнэлж, дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээ	1	14	112	13400	1,500,000
	<b>НИЙТ ДҮН</b>					<b>1,500,000</b>

Жич: 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн УАГ-2020/364 дугаартай ажлын даалгаврын хавсралт

Хянасан:

ГҮЙЦЭГТЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*[Signature]*

С.ОЮУНГЭРЭЛ

Д.НАРАНЦЭЦЭГ

Боловсруулсан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

*[Signature]*

Б.САРУУЛ

Төсөв хянасан:  
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

АХЛАХ НИГЭМЛЭН БОДОГЧ, АХЛАХ  
ШИНЖЭЭЧ  
Т.МЯГМАРЖАВ